

БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 20

Өргөн

Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, дүрэм журмын шинэчлэлийн дагуу байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах ажлыг зохин байгуулан ажилласан. Байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдад чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ажлыг дотоод журамдаа тусган хэрэгжүүлсэн байна. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ийн шинэчлэлийн дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн зохион байгуулж журмын хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Мөн төрийн албаны “ХНУМТ” цахим системд мэдээллийг үнэн зөв оруулах, мэдээллийн шинэчлэн ажилласан.

Тухайн шатны байгууллагад хамаарах сул орон тооны зарыг дээд шатны төрийн албаны зөвлөлд хүргүүлэн тухай бүр орон тоог Төрийн албаны зөвлөлийн сул орон тоог нөхөх зар дээр байршуулан ажилласан.

2024 оны 06 сарын 30-ний өдөр Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч тэтгэвэр тогтоолгох өндөр насын дээд хязгаарт тогтоох насанд хүрж ажлаас чөлөөлөгдсөн. 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нягтлан бодогчийн сонгон шалгаруулалтын дүнгээр нягтлан бодогчийг томилсон. Нийгмийн бодлогын мэргэжилтэн шилжин ажиллах хүсэлтээр тухайн албан тушаалын сул орон тооны мэдээллийг төрийн албаны зөвлөл рүү хүргүүлж, 2024 оны 4-р улирлын Төрийн жинхэнэ албаны нөөцөд тус сумаас 1 иргэн тэнцэж, тусгай шалгалтын дүнгээр тус сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн томилогдож орон тоог бүрдүүлэн ажилласан.

2024 оны жилийн эцсийн дүнгээр Хөдөө аж ахуйн тасагт Хөдөө аж ахуйн мэргэжилтэн, хүнс жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтний орон тооны зарыг дээд шатны Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.

оОо